

2000 оны мал тооллого

I. ОРШИЛ

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн 80 гаруй хувийг эзэлдэг мал аж ахуйн салбарын хөгжил, түүний бүтээгдэхүүний өсөлтөөс улс орны эдийн засаг бүхэлдээ ихээхэн шалтгаалдаг билээ. Нийт малын тоо 2000 оны эцэсд 30.2 саяд хүрч 1999 оныхоос 3341.4 мянган толгойгоор буурсан байна.

2000 оны мал тооллогоор цэвэр, эрлийз мал, хөдөө аж ахуйд ажиллаж байгаа мэргэжлийн боловсон хүчин, ашиглагдаж байгаа машин техник, хашаа, уст цэгийн тооллогыг хамтруулан явууллаа.

Мал тооллогын бэлтгэл зохион байгуулалтыг хангах, маягт, зааварчилгааг орон нутагт хүргүүлэх, тооллогын маягт, заавар арагачлалд гарсан өөрлөлтийн талаар Үндэсний статистикийн газраас нийт аймаг, нийслэлийн засаг даргын тамгын газар, статистикийн албадад семинар, удирдамж өгч байлаа.

Аймаг, сум, нийслэл, дүүргүүдэд мал тооллогын ажлыг удирдан зохион байгуулж явуулах комисс ажиллуулж, нэгдсэн семинар зөвлөгөөн орон нутагт зохиогдон, тооллогын үеэр сумдад хяналт шалгалтын групп томилон ажиллуулав.

Үндэсний статистикийн газраас Дундговь, Баянхонгор, Өвөрхангай, Завхан, Увс аймгуудад мал тооллогын ажлыг хянах хяналт, шалгалтын групп томилуулан ажилуулав.

Дундговь, Өвөрхангай аймгуудын 2-3 сумдад хяналтын тооллого хийх үеэр зарим хэсгийн төлөөлөгчид малыг нүдээр үзэж тоолох зарчмыг баримтлаагүй, маягтын үзүүлэлтийг огт бөглөөгүй, дутуу бөглөсөн, малыг орхигдуулан тоолсон зэрэг зөрчил гарсныг залруулж, алдаа гаргасан хүмүүст зохих хариуцлага хүлээлгэлээ.

2000 оны мал тооллогын ажлыг зохих заавар журмын дагуу явуулж, мал сүргийг тооллогод бүрэн хамруулах, тооллогын үнэн зөв байдлыг хангуулах талаар аймаг, нийслэлийн Засаг дарга түүний тамгын газраас зориуд анхаарч, дэмжлэг туслалцаа үзүүлэн зохион байгуулсныг тэмдэглэж байна.

I. Малчдын тоо, тэдний соёл, ахуйн байдал

I.1. Малчдын тоо, насны бүлэг. 2000 оны жилийн эцсийн мал тооллогоор улсын хэмжээгээр 191.5 мянган малчин өрхөд 421.4 мянган малчид байна. Малчдын тоо өмнөх оныхоос 0.8 хувь буюу 3.7 мянгаар нэмэгдэв.

Нийт малчдын 55.9 хувь нь 16-34 насны залуучууд, 30.9 хувь нь 35-аас тэтгэвэрт гарах хүртлэх насны хүмүүс байна. Малчдын дотор тэтгэвэрийн насны хүмүүсийн хувийн жин жилээс жилд буурах хандлагатай байна.

Өрх, малчдын тоо, бүрэлдэхүүн

	1995	1997	1998	1999	2000	2000\1999 хувь
Малчин өрх (мян)	169.3	183.6	187.1	189.9	191.5	100.8
Малчдын тоо (мян)	390.5	409.6	414.4	417.7	421.4	100.9
Үүнээс:16- 34 насны	225.2	223.9	231.3	233.7	235.7	100.9
35-аас тэтгэвэрт гарах хүртэл насны	95.4	123.4	125.4	126.8	130.3	102.8
Тэтгэврийн насны	69.9	62.3	57.7	57.2	55.4	96.9
Насны бүрэлдэхүүн (хувиар)	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Үүнээс:16- 34 насны	57.7	54.7	55.8	55.9	55.9	100.1
35-аас тэтгэвэрт гарах хүртэл насны	24.4	30.1	30.3	30.4	30.9	101.7
Тэтгэврийн насны	17.9	15.2	13.9	13.7	13.2	96.4
Нэг малчин өрхөд ногдох малын тоо* (тол)	169	170	176	177	158	89.2

* Нийт малд оногдуулж бодсоноор

1999 онд нэг малчин өрхөд дунджаар 177 толгой мал ногдож байсан бол 2000 онд 158 толгой болов. Нэг малчин өрхөд ногдох малын тоо Сүхбаатар, Хэнтий, Дархан, Орхон аймгуудад өсч, бусад аймгуудад буурчээ.

Сүхбаатар, Говьсүмбэр, Өмнөговь, Говь-Алтай, Сэлэнгэ, Дорноговь аймгийн нэг малчин өрхөд 204-247 толгой мал ногдож байхад Улаанбаатар, Өвөрхангай, Баян-Өлгий, Архангай, Орхон, Хөвсгөл, Увс, Дархан аймагт 103-145 толгой мал ногдож байна. (Хавсралт 1)

I. 2. Малчдын соёл, ахуйн зарим үзүүлэлт. 2000 оны байдлаар нийт малчин өрхийн дотор 20.4 мянган өрх цахилгааны эх үүсгэвэртэй, 24.6

мянган өрх телевизортэй, 16.6 мянган өрх авто машинтай, 31.7 мянган өрх мотоциклтэй, 2.8 мянган өрх трактортай байна.

Малчин өрхийн 10.6 хувь цахилгааны эх үүсгэвэртэй, 12.8 хувь телевизортэй, 8.7 хувь авто машинтай, 16.6 хувь мотоциклтэй байна.

Нийт малчин өрхөд цахилгааны эх үүсгэвэртэй өрхийн эзлэх хувь өмнөх оныхоос 0.2 пункт, телевизортой өрхийн эзлэх хувь 1.5, трактортой өрхийн эзлэх хувь өмнөх оныхоос 0.1 пунктээр буурч, машин, мотоцикльтэй өрхийн эзлэх хувь 1.2-2.5 пунктээр өссөн байна.

Харин Архангай, Баян-Өлгий, Булган, Завхан, Увс, Дорнод аймгийн малчин өрхийн 2.6-5.8 хувь цахилгаантай байгаа нь аймгууд дотроос хамгийн доогуур түвшинд байна.

2000 онд цахилгаан гэрэл телевизортой өрхийн тоо буурч, машин, мотоциклтэй өрхийн тоо нэмэгджээ. Аймгууд дотроос говийн бүсийн машин, мотоциклоор илүүтэй хангагдсан байна. (Хавсралт 2, 3)

Малчин өрхийн соёл, ахуйн хангамжийн зарим үзүүлэлт

	Өрхийн тоо, мян			2000\1999 хувь	Малчин өрхийн тоонд эзлэх хувь	
	1997	1999	2000		1999	2000
Цахилгаантай	18.7	20.6	20.4	99.0	10.8	10.6
Телевизортэй	19.0	27.1	24.6	90.8	14.3	12.8
Автомашинтай	7.3	11.9	16.6	139.5	6.2	8.7
Мотоциклтэй	26.2	29.2	31.7	108.6	15.4	16.6
Трактортай		3.0	2.8	93.3	1.6	1.5

1.3. ХАА-н үйлдвэрлэлд ажиллаж байгаа боловсон хүчин, ашиглаж байгаа машин, техникийн тоо. 2000 онд ХАА-н үйлдвэрлэлд малын эмч 2032, мал зүйч 1135, агрономич 477, механикжуулагчид 4263 ажиллаж байгаа бөгөөд малын эмчийн тоо 1996 оныхоос 0.5 мянгаар, мал зүйчийн тоо 0.7 мянгаар нэмэгдэжээ.

Малын эмчийн 24.9, мал зүйчийн 27.6, агрономичийн 53.2 тус тус дээд боловсролтой байна.

Хөдөө аж ахуйн компани, хоршоонд 343 малын эмч, 120 мал зүйч, 136 агрономич, 2331 механикжуулагч ажиллаж байна.

Мөн хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд 4733 трактор, 1086 үр тарианы комбайн, 112 төмсний комбайн, 1098 анжис, 1995 тариа үрлэгч, 2232 борной, 6621-8486 ачааны болон суудлын машин, 2989 цөцгий ялгагч ашиглагдаж байгаа нь 1996 оныхоос трактор 2.3 мянгаар, үр тарианы комбайн 0.3 мянгаар, тариа үрлэгч 0.9 мянгаар тус тус буурчээ. (Хавсралт 4, 5)

ХАА-н боловсон хүчин, ашиглагдаж байгаа машин, техникийн тоо (мян)

	1989	1992	1996	2000
Мэргэжилтэн				
Мал зүйч	1.2	0.5	0.4	1.1
Малын эмч	1.8	1.7	1.5	2.0

Агрономич	-	-	0.2	0.5
Механикжуулагч	-	-	6.2	4.3
Машин, техник				
Трактор	11.5	9.0	7.0	4.7
Үр тарианы комбайн	2.5	2.1	1.4	1.1
Тариа үрлэгч	6.2	5.3	2.9	2.0
Анжис	2.2	1.6	1.4	1.1

II. МАЛ ТЭЖЭЭВЭР АМЬТАДЫН ТОО, БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН

II.1. Малын тоо, бүрэлдэхүүн, тархалт.

Малын тооны өсөлт. 2000 оны эцэст 30.2 сая мал тоологдсон нь 1999 оныхоос 10.0 хувь буюу 3341.4 мянган толгойгоор буурлаа. Урьд оныхоос хонь 1314.9 мянга, адуу 502.7 мянга, үхэр 727.1 мянга, ямаа 764.0 мянга, тэмээ 32.7 мянгаар буурсан байна.

Бодод шилжүүлснээр малын тоо урьд оныхоос 13.9 хувь буюу 1593.4 мянгаар буурлаа.

Малын тоо (мян.тол)

	1990	1995	1997	1998	1999	2000	2000/1999	
							%	Зөрүү
Бодоор *	9071.5	9868.2	10683.2	11151.5	11432.6	9839.2	86.1	-1593.4
Толгойн тоо	25856.9	28572.3	31292.3	32897.5	33568.9	30227.5	90.0	-3341.4
Тэмээ	537.5	367.5	355.4	356.5	355.6	322.9	90.8	-32.7
Адуу	2262.0	2648.4	2893.2	3059.1	3163.5	2660.7	84.1	-502.7
Үхэр	2848.7	3317.1	3612.9	3725.8	3824.7	3097.6	81.0	-727.1
Хонь	15083.0	13718.6	14165.6	14694.2	15191.3	13876.4	91.3	-1314.9
Ямаа	5125.7	8520.7	10265.3	11061.9	11033.9	10269.8	93.1	-764.0

* Бодод шилжүүлэхдээ адуу, үхрийг нэг бод, тэмээг 1.5 бод, 6 хонь, 8 ямааг тус бүр нэг бод гэж тооцов.

Орхон; Хэнтий, Дархан-Уул, Дорнод, Сэлэнгэ, Сүхбаатар аймгууд малаа толгойн дүнгээр 9.1-41.9 мянгаар өссөн байна. Малаа таван төрөл дээр өсгөсөн аймаг гарсангүй. (Хавсралт 10)

Урьд онд цас зудтай, хүндрэлтэй өвөлжсөн Увс, Завхан, Өвөрхангай, Дундговь аймгуудын малын тоо 310.5-822.4 мянган толгойгоор буурчээ.

1999-2000 оны өвөл, хавар манай орны 13 аймгийн 157 сумыг хамарсан зуднаар том мал, төлийн хорогдол их гарч, эх малын хээл хаялт, сувайралт нэмэгдсэн нь малын тоо, толгой өмнөх оныхоос буурах үндсэн шалтгаан болов.

2000 онд малын тоо буурахад нөлөөлсөн хүчин зүйлс (мян.тол)

	1990	1995	1997	1998	1999	2000	2000\1999	
							хувь	зөрүү
Бойжуулсан төл	9519.1	9012.4	9537.3	9907.3	10220.9	8273.3	80.9	-1947.6
100 эхээс бойжуулсан төл	83	78	81	76	74	59	79.7	-15
Том малын зүй бус хорогдол	673.2	673.9	617.7	785.7	800.1	491.2	436.3	2691.1
Хээл хаясан хээлтэгч	355.2	386.6	540.1	532.2	654.5	1205.5	184.2	551.0
Сувайрсан хээлтэгч	840.8	889.7	1042.6	967.8	1258.5	1494.4	118.7	235.9

2000 онд 1999 оныхоос том малын зүй бус хорогдол 2.7 саяаар нэмэгдсэн байна. Хээлтэгч малын 19.1 хувь буюу 2699.9 мал хээл хаяж, сувайрч, бойжуулсан төлийн тоо 1.9 саяар буурчээ.

1990 оноос хойших сүүлийн 10 жилийн малын өсөлт

	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Өссөн жилийн тоо	7	2	6	6	4	8
Буурсан жилийн тоо	3	8	4	4	6	2
1999 оныхоос өссөн хэмжээ (мян.тол)	5791.7		398.7	248.9		5144.1
1990 оныхоос буурсан хэмжээ (мян.тол)	-1421.2	-214.6			-1206.6	

Мал хувьчлагдаж эхэлсэн 1990 оноос хойшхи 10 жилд 1991, 1993, 2000 онуудад малын тоо өмнөх оныхоос буурч, үлдсэн 7 жилд нь малын тоо өсч байсан байна. Мөн өнгөрсөн 10 жилд малын тооны өсөлт, бууралт төрөл дотроо жигд биш байсан бөгөөд харин 1998 онд таван төрөл дээрээ өсчээ.

Малын, тоо толгойн хүрсэн дээд хэмжээг үзүүлбэл:

	1918 оноос хойш		Жилийн эцэст тоолдог болсон 1961 оноос хойш	
	мян.тол	он	мян.тол	он
Бүгд	33568.9	1999	33568.9	1999

Тэмээ	895.3	1954	751.7	1961
Адуу	3163.4	1999	3163.5	1999
Үхэр	3824.7	1999	3824.7	1999
Хонь	15936.4	1941	15191.3	1999
Ямаа	11061.9	1998	11061.9	1998

Нийт малын тооны өсөлт, бууралт. (бүс нутгаар)

	Толгойн тоо (мян.тол)						2000\1999	
	1990	1995	1997	1998	1999	2000	хувь	зөрүү
Өрнөд								
Дүн	8499.7	9682.9	9971.2	9798.6	9665.3	8702.4	90.0	-962.9
Баян-Өлгий	1318.4	1354.2	1519.4	1345.9	1362.4	1310.4	96.2	-52.0
Говь-Алтай	1693.6	2102.5	2112.5	2113.1	2113.2	2035.1	96.3	-78.1
Завхан	2133.4	2401.4	2556.5	2603.6	2432.0	1941.3	79.8	-490.7
Увс	1666.6	1754.2	1856.3	1940.1	1889.8	1579.3	83.6	-310.5
Ховд	1687.7	2070.6	1926.5	1795.9	1867.9	1836.3	98.3	-31.6
Нийт малд эзлэх хувь	32.9	33.9	31.9	29.8	28.8	28.8	100.0	0.0
Дундад								
Дүн	8027.1	9443.0	10532.5	11306.8	11794.7	10543.2	89.4	-1251.5
Архангай	1496.3	1626.4	1924.2	2119.3	2335.5	2216.1	94.9	-119.4
Баянхонгор	1599.1	2227.1	2428.0	2511.3	2475.1	2375.7	96.0	-99.4
Өвөрхангай	2061.6	2595.0	2718.2	2921.5	2956.6	2159.0	73.0	-797.6
Хөвсгөл	1871.9	1857.4	2152.3	2295.8	2418.2	2269.6	93.9	-148.6
Булган	998.2	1137.1	1309.8	1458.9	1609.3	1522.8	94.6	-86.5
Нийт малд эзлэх хувь	31.0	33.0	33.7	34.4	35.1	34.9	99.3	-0.3
Өмнөд								
Дүн	3359.9	3907.2	4615.1	4970.1	4960.8	3921.5	79.0	-1039.3
Говьсүмбэр		103.1	117.8	135.7	136.5	112.5	82.4	-24.0
Дорноговь	943.5	886.2	963.2	1017.8	1110.2	1036.6	93.4	-73.6
Дундговь	1505.5	1714.4	2025.7	2212.8	2105.2	1282.8	60.9	-822.4
Өмнөговь	910.9	1203.5	1508.4	1603.8	1608.9	1489.6	92.6	-119.3
Нийт малд эзлэх хувь	13.0	13.7	14.7	15.1	14.8	13.0	87.8	-1.8
Дорнод								
Дүн	3440.0	2707.9	3044.3	3412.6	3724.7	3790.1	101.8	65.4
Хэнтий	1498.7	1100.9	1254.0	1388.7	1462.3	1471.4	100.6	9.1
Дорнод	936.6	591.4	657.2	735.7	811.8	826.2	101.8	14.4
Сүхбаатар	1004.7	1015.6	1133.1	1288.2	1450.6	1492.5	102.9	41.9
Нийт малд эзлэх хувь	13.3	9.5	9.5	10.4	11.1	12.5	113.0	1.4
Төв								
Дүн	2530.2	2831.3	3129.2	3409.4	3423.4	3270.2	95.5	-153.2
Сэлэнгэ	512.5	504.7	522.5	569.4	622.6	654.5	105.1	31.9
Төв	1711.4	1766.4	2048.4	2238.5	2218.1	2022.1	91.2	-196.0
Дархан-Уул	109.2	138.6	136.8	168.2	179.4	194.5	108.4	15.1
Орхон	53.5	127.3	120.3	132.3	163.9	168.5	102.8	4.6

Улаанбаатар	143.6	294.3	301.2	301.0	239.4	230.6	96.3	-8.8
Нийт малд эзлэх хувь	9.8	9.9	10.0	10.4	10.2	10.8	106.1	0.6

Нийт малыг аймгуудаар бензиний бүсээр ангилан авч үзвэл нийт малын 28.8 хувь нь өрнөд, 34.9 хувь нь өмнөд, 12.5 хувь нь дорнод, 10.8 хувь нь төв бүсийн аймгуудад байна.

2000 онд нийт сүрэгт хонины эзлэх хувийн жин 0.7, ямааны эзлэх хувийн жин 1.1 пунктээр тус тус өсч, харин адуу, үхрийн эзлэх хувийн жин 0.6-1.2 пунктээр тус тус буурсан байна.

Нийт сүрэгт ямааны эзлэх хувийн жин жилээс жилд өссөөр байна. Тухайлбал : 1990 онд бог малд ямааны эзлэх хувь 25.4, 1999 онд 42.1 хувь байсан, 2000 онд 42.5 хувь боллоо.

Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувь

	1990	1995	1996	1997	1998	1999	2000
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Тэмээ	2.1	1.3	1.2	1.1	1.1	1.1	1.1
Адуу	8.8	9.3	9.4	9.3	9.3	9.4	8.8
Үхэр	11.0	11.6	11.9	11.5	11.3	11.4	10.2
Хонь	58.3	48.0	46.3	45.3	44.7	45.2	45.9
Ямаа	19.8	29.8	31.2	32.8	33.6	32.9	34.0

Улсад нийт малын тоогоор Баянхонгор, тэмээгээр Өмнөговь, адуугаар Архангай, үхрээр Архангай, хониор Төв, ямаагаар Баянхонгор аймгууд тэргүүн байранд байна. (Хавсралт 6)

Манай улс дэлхийн улс орнуудын дотор адуугаар 6, ямаагаар 7, үхрээр 15 дугаар байранд орж байна.

Адуу, тэмээ, ямааны тоо (мян.тол)

Улсын нэр	Адууны тоо	Улсын нэр	Тэмээний тоо	Улсын нэр	Ямааны тоо
1.Хятад	8855	1.Сомали	6100	1.Хятад	137717
2.Бразил	6400	2.Судан	3100	2.Энэтхэг	120560
3.Мехсик	6250	3.Мавритан	1183	3.Пакистан	48575
4.АНУ	6150	4.Пакистан	1100	4.Судан	37346
5.Аргентин	3300	5.Энэтхэг	1030	5.Бангладеш	33500
6.Монгол	3163	6.Этиоп	1030	6.Иран	27000
7.Этиоп	2750	7.Кени	825.0	7.Нигери	24500
8.Колумби	2300	8.Чад	677.0	8.Этиоп	16850
9.Орос	1312	9.Саудын араб	422.0	9.Индонези	15200
10.Казахстан	1083	10.Нигер	392.0	10.Бразил	12600
		11.Мали	365.0	11.Сомали	12500
		12.Монгол	356.0	12.Монгол	11034

Тайлбар : Дэлхийн улсуудын малын тоог 1998 оноор авсан болно.

Манай улс дэлхийд нэг хүн амд ногдох адуу, ямаагаар тэргүүн байр, тэмээ, хониор 3 дугаар байранд тус тус орж байна.

Нэг хүн амд ногдох малын тоогоор эхний байруудад ордог улс орнуудыг үзүүлбэл : (толгой)

Адуугаар		Тэмээгээр		Хониор		Ямаагаар	
1.Монгол	1.32	Сомали	0.60	Шинэ зеланд	12.54	Монгол	4.62
2.Аргентин	0.09	Мавритан	0.47	Австрали	6.46	Мавритан	1.63
3.Казахстан	0.07	Монгол	0.15	Монгол	6.33	Сомали	1.35
4.Мексик	0.07	Судан	0.11	Уругвай	5.41	Судан	1.32
5.Колумби	0.06	Чад	0.09	Судан	1.50	Мали	0.80

Хувийн (амины) малын тоо. 2000 онд улсын хэмжээгээр аминдаа малтай 268.7 мянган өрх тоологдсоны дотор 71.3 хувь буюу 191.5 мянга нь малчин өрх байна. Хувийн малын тоо 2000 онд нийт малын 96.7 хувийг эзлэх болж 29.2 саяд хүрлээ.

Ямаа, адууны 98.1 хувь, бусад төрлийн малын 95.2 – 97.8 хувь нь хувийн аж ахуйд ногдох болжээ.

Өнгөрсөн онд малаа өсгөсөн дээрхи 6 аймгуудаас бусад аймгуудын хувийн малын тоо урьд оныхоос буурсан байна.

Нийт малын тооны өсөлт, бууралт. (бүс нутгаар)

	Толгойн тоо (мян.тол)						2000\1999	
	1990	1995	1997	1998	1999	2000	Хувь	зөрүү
Өрнөд								
Дүн	2943.9	9300.8	9696.7	9577.6	9509.2	8588.3	90.3	-920.9
Баян-Өлгий	607.6	1324.6	1494.7	1330.7	1349.3	1299.9	96.3	-49.4
Говь-Алтай	525.8	2044.3	2070.7	2077.7	2079.0	2006.6	96.5	-72.4
Завхан	676.4	2330.4	2505.6	2560.1	2404.4	1924.0	80.0	-480.4
Увс	550.1	1657.0	1780.7	1880.7	1847.5	1550.7	83.9	-296.8
Ховд	584.0	1944.5	1845.0	1728.4	1829.0	1807.1	98.8	-21.9
Дундад								
Дүн	2751.5	8985.7	10184.0	11032.0	11563.5	10395.6	89.9	-1167.9
Архангай	565.4	1577.9	1900.8	2096.7	2316.0	2199.5	95.0	-116.5
Баянхонгор	505.1	2134.8	2359.3	2477.0	2445.7	2351.6	96.2	-94.1
Булган	273.7	1018.6	1210.0	1382.0	1543.1	1473.5	95.5	-69.6
Өвөрхангай	801.4	2465.3	2611.8	2829.8	2881.6	2137.0	74.2	-744.6
Хөвсгөл	605.9	1789.1	2102.1	2246.5	2377.1	2234.0	94.0	-143.1
Өмнөд								
Дүн	1012.3	3656.5	4375.5	4736.7	4753.5	3780.1	79.5	-973.4
Говьсүмбэр		59.6	79.1	96.9	106.9	94.0	87.9	-12.9
Дорноговь	269.9	776.5	867.4	926.4	1018.9	960.5	94.3	-58.4
Дундговь	438.6	1660.8	1970.5	2157.8	2063.5	1266.3	61.4	-797.2
Өмнөговь	303.8	1159.6	1458.5	1555.6	1564.2	1459.3	93.3	-104.9
Дорнод								
Дүн	765.0	2321.4	2695.4	3077.4	3408.3	3500.3	102.7	92.0

Сүхбаатар	286.8	894.8	1042.5	1209.6	1377.7	1423.1	103.3	45.4
Хэнтий	308.8	959.7	1103.3	1231.0	1316.1	1338.3	101.7	22.2
Дорнод	169.4	466.9	549.6	636.8	714.5	738.9	103.4	24.4
Төв								
Дүн	770.2	2182.8	2577.4	2932.5	3044.3	2972.3	97.6	-72.0
Сэлэнгэ	123.1	314.0	371.1	442.4	511.8	566.6	110.7	54.8
Төв	512.3	1420.8	1747.2	1968.8	2010.0	1859.7	92.5	-150.3
Дархан-Уул	38.0	102.4	103.8	139.3	153.7	173.5	112.9	19.8
Орхон	19.3	95.4	99.3	113.8	150.2	157.5	104.9	7.3
Улаанбаатар	77.5	250.2	256.0	268.2	218.6	215.0	98.4	-3.6

Хувийн аж ахуйд байгаа малын бүтцийг авч үзвэл хонь 45.2 хувь, ямаа 34.5, үхэр 10.4, адуу 8.9, тэмээ 1.1 хувийг эзлэж байна. Хувийн мал аж ахуйд байгаа малын тоо 1990 оныхтой харьцуулахад 20.9 саяар нэмэгдэж, 1999 оныхтой харьцуулахад 3.0 саяар багассан байна.

Хувийн мал аж ахуйн мал, төрлөөр (мян.тол)

	Малтай өрхийн тоо	Бүгд	Ү ү н э э с				
			тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа
1990	262.3	8242.9	88.2	1108.1	1457.5	3684.7	1904.4
1991	288.9	14002.6	186.3	1492.1	1896.6	7209.4	3218.2
1992	301.5	18081.1	253.7	1728.0	2237.4	9589.1	4272.9
1993	289.7	22565.2	335.0	2026.8	2503.5	11902.0	5797.9
1994	289.2	24527.2	343.3	2279.0	2811.8	12133.8	6959.3
1995	283.9	26447.2	349.7	2532.0	3140.4	12194.1	8231.0
1996	278.3	27365.2	342.6	2670.6	3323.4	12184.6	8844.0
1997	279.7	29529.0	343.8	2807.4	3485.3	12912.0	9980.5
1998	275.0	31356.3	346.4	2982.6	3613.5	13630.1	10783.8
1999	270.0	32278.7	346.4	3097.3	3733.2	14306.5	10795.3
2000	268.7	29236.7	315.5	2609.4	3028.3	13206.0	10077.5

Иргэдийн малын бүлэглэлтээс үзвэл 100 хүртэл малтай ядуу, ядуувтар өрх өмнөх онд нийт малтай өрхийн 58.5 хувийг эзлэж байсан бол 2000 онд 63.2 хувь болж 4.7 пунктээр нэмэгдсэн байна.

Иргэдийн хувийн малын бүлэглэлт

	Малтай өрхийн тоо		Дүнд эзлэх хувь		Малын тоо (мян.тол)	
	1999	2000	1999	2000	1999	2000
ДҮН	269950	268732	100.0	100.0	32278.6	29236.6
10 хүртэл малтай	28669	31361	10.6	11.7	164.3	184.0
11-30 малтай	35970	40436	13.3	15.0	743.4	833.1
31-50 малтай	31837	35041	11.8	13.0	1325.4	1431.5
51-100 малтай	61347	63096	22.7	23.5	4710.9	4714.7
101-200 малтай	67840	59821	25.1	22.3	9598.4	8424.9
201-500 малтай	37635	33408	14.0	12.4	10874.8	9607.5
501-999 малтай	5438	4591	2.0	1.7	3447.7	2870.7

1000-1499 малтай	1061	893	0.4	0.3	1196.3	1004.8
1500-2000 малтай	75	48	0.0	0.0	124.8	79.5
2001-с дээш мал	41	37	0.0	0.0	92.8	85.9

“ Бүлэглэлтэд алдуул мал ороогүй

Одоо 50 хүртэл малтай өрхүүд тэмээнээс бусад малтай байгаагийн дотор 10 хүртэл малтай өрх дунджаар 1 адуу, 3 үхэр, 2 бог малтай байна.

Нэг өрхөд ногдох хувийн малын бүлэглэлт 2000 оны байдлаар. (толгой)

	Малтай өрхийн тоо		Дүнд эзлэх хувь		Малын тоо (мян.тол)	
	1999	2000	1999	2000	1999	2000
ДҮН	109	1	10	11	49	38
10 хүртэл малтай	6		1	3	1	1
11-30 малтай	21		3	6	6	6
31-50 малтай	41		5	8	15	13
51-100 малтай	75	1	8	10	31	26
101-200 малтай	141	1	13	14	62	51
201-500 малтай	288	4	23	21	136	104
501-999 малтай	625	8	48	40	330	199
1000-1499 малтай	1125	11	87	75	657	296
1500-2000 малтай	1657	12	130	86	1019	410
2001-с дээш мал	2323	15	166	144	1529	468

Улсын дунджаар малтай нэг өрхөд (бодод шилжүүлснээр) 37 бод буюу 109 толгой хувийн мал ногдож байгаа нь өмнөх оныхоос 4 бод буюу 11 толгойгоор буурчээ. Өрнөд, Дорнод, Говийн бүсийн аймгуудын 1 малтай өрхөд улсын дунджаас дээгүүр буюу 116-148 мал, Төв, Дундад бүсийн аймгуудад улсын дунджаас доогуур буюу 72-106 мал ногдож байна.

Малтай нэг өрхөд ногдох хувийн малын тоо, бүс нутгаар

	Бодод шилжүүлснээр : Толгойн тоогоор					
	1998	1999	2000	1998	1999	2000
ӨРНӨД						
Дүн	36	36	31	124	126	116
Баян-Өлгий	25	24	22	88	88	84
Говь-Алтай	40	39	37	164	163	159
Завхан	45	44	34	140	137	116
Увс	33	33	27	108	112	99
Ховд	36	39	37	124	137	134
ДУНДАД						
Дүн	41	44	37	113	118	106
Архангай	41	44	41	95	103	96
Баянхонгор	41	42	39	145	146	140
Булган	50	53	50	119	130	125
Өвөрхангай	40	41	27	122	124	91
Хөвсгөл	39	42	38	96	101	96

ӨМНӨД						
Дүн	57	59	46	181	182	148
Говьсүмбэр	31	35	37	85	94	94
Дорноговь	54	59	59	149	162	153
Дундговь	62	63	36	204	204	128
Өмнөговь	57	56	53	187	181	175
ДОРНОД						
Дүн	43	48	48	103	115	118
Сүхбаатар	34	37	40	76	84	84
Хэнтий	47	54	57	119	136	139
Дорнод	46	50	55	109	119	126
ТӨВ						
Дүн	26	28	26	67	75	72
Сэлэнгэ	17	19	22	42	49	54
Төв	42	44	41	109	116	111
Орхон	22	27	22	56	73	61
Дархан-Уул	11	17	18	28	43	45
Улаанбаатар	13	12	12	33	29	28
ДҮН	39	41	37	114	120	109

Хээлтэгч мал. 2000 оны эцэст 13244.3 мянган хээлтэгч мал тоологдсон нь урьд оныхоос 910.0 мянгаар буурсны дотор эм хонь 428.6, гүү 98.3 мянга, үнээ 235.6 мянга, ингэ 6.7 мянгаар, эм ямаа 140.8 мянгаар тус тус буурлаа. (Хавсралт 20,22)

Хээлтэгч малын тоо (мян.тол)

	1990	1995	1997	1998	1999	2000	2000\1999	
							Хувь	Зөрүү
Ингэ	140.9	101.3	97.7	97.9	101.4	94.8	93.4	-6.7
Гүү	563.5	707.1	783.2	836.6	921.5	823.1	89.3	-98.3
Үнээ	1127.2	1177.8	1370.8	1432.8	1449.8	1214.3	83.8	-235.6
Эм хонь	7786.1	5948.3	6370.6	6667.9	6846.5	6417.9	93.7	-428.6
Эм ямаа	2425.7	3607.7	4473.2	4890.3	4835.2	4694.3	97.1	-140.8
ДҮН	12043.4	11542.2	13095.5	13925.5	14154.4	13244.3	93.6	-910.0

Баян-Өлгий, Дорнод, Сүхбаатар, Сэлэнгэ, Хэнтий, Дархан, Ховд, Орхон аймгууд хээлтэгч малынхаа тоог урьд оныхоос өсгөсөн байна. Харин Увс, Завхан, Дундговь, Өвөрхангай аймгуудад 110.3-234.0 мянган хээлтэгч хорогдсон байна.

1990 оноос хойш олон хээлтэгч мал тоологдсон жил

	мян.тол	Он		мян.тол	Он

Ингэ	140.9	1990	Эм хонь	7786.1	1990
Гүү	921.5	1999	Эм ямаа	4890.3	1998
Үнээ	1449.8	1999			

Төл бойжилт. 2000 онд гарсан төлийн 82.6 хувь буюу 8273.3 мянган төл бойжуулав. Бойжсон төлийн тоо өмнөх оныхоос 1947.6 мянгаар буюу 19.1 хувиар буурчээ. Бойжуулсан нийт төлөөс 4.5 мянгыг каракуль арьсанд нядалсан байна. Бойжуулсан төл бүх төрөл дээрээ өмнөх оныхоос бууралтай байна. Дундговь, Өвөрхангай аймгуудад гарсан төлийнхөө 61.1-69.5 хувийг бойжуулсан байна. (Хавсралт 24)

Төл бойжилт (мян.тол)

	Бүгд	Ү Ү Н Э Э С				
		ботго	унага	тугал	хурга	ишиг
Гарсан	10018.3	39.0	438.9	892.5	5320.7	3327.2
Бойжсон	8273.3	32.6	368.8	790.3	4412.7	2668.9
Хорогдсон	1745.0	6.4	70.1	102.2	908.0	658.3
Бойжилтын хувь	82.6	83.5	84.0	88.6	82.9	80.2

1990-2000 онуудад бойжуулсан төлийн тоо 4 жилд нь буурч, 7 жилд нь өсч байсан байна.

Бойжуулсан төл (мян.тол)

	1991-1995 оны дундаж	1990	1995	1997	1998	1999	2000
Ботго	42.3	57.9	40.5	39.3	38.4	37.9	32.6
Унага	357.4	338.1	451.2	471.9	516.5	527.9	368.8
Тугал	778.1	754.8	920.4	944.6	980.0	1035.3	790.3
Хурга	5431.3	6522.0	4969.2	4946.4	5094.5	5245.4	4412.7
Ишиг	2141.5	1846.3	2631.1	3135.1	3277.9	3374.4	2668.9
Бүгд	8750.6	9519.1	9012.4	9537.3	9907.3	10220.9	8273.3

1990 оноос хойш хамгийн олон төл бойжуулсан жил

	мян.төл	он		мян.төл	Он
Бүгд	10220.9	1999	Тугал	1035.3	1999
Ботго	57.9	1990	Хурга	6522.0	1990
Унага	527.9	1999	Ишиг	3374.4	1999

2000 онд 100 эхээс бойжуулсан төлийг өмнөх оныхтой зэрэгцүүлж үзвэл ботго 7, унага 23, хурга, ишиг 14-өөр бага байна. (Хавсралт 25)

100 эхээс бойжуулсан төл

	1991-1995 оны дундаж	1990	1995	1996	1997	1998	1999	2000
Ботго	36	38	40	37	40	39	39	32
Унага	61	61	69	66	64	66	63	40
Тугал	72	70	79	78	78	72	72	55
Хурга	77	88	79	82	85	80	79	65
Ишиг	78	82	80	76	81	73	69	55
Бүгд	76	83	78	78	81	76	74	59

100 хээлтэгчээс Дархан-Уул, Баян-Өлгий, Дорнод, Сүхбаатар, Орхон аймаг 71-84 төл бойжуулсан байхад Өмнөговь, Баянхонгор, Дундговь, Төв, Өвөрхангай, Увс, Завхан, Дорноговь аймгуудад 22-58 төл бойжуулжээ.

Том малын зүй бус хорогдол. 2000 оны эхний малын 10.4 хувьтай тэнцэх 3491.2 мянган том мал зүй бусаар хорогдсон нь урьд оныхоос 2691.0 мянгаар их байна. 2000 онд хорогдсон нийт малын тоог зах зээлийн дундаж үнээр үнэлбэл 140.7 тэрбум төгрөгийн хохирол улсад учирсан тооцоо гарч байна. Өнгөрсөн жилийн манай оронд учирсан зуд нь хамарсан нутаг дэвсгэр, учирсан хохирлын хэмжээгээрээ сүүлийн 50 жилд Монголд үзэгдээгүй гамшиг боллоо. Статистикийн эх сурвалжаас үзвэл 1944-1945 оны өвөл буюу “ Мичин жил “-ийн зуднаар 7.5 сая, 1950 онд 3.9 сая мал зуднаар хорогдсон мэдээ бий.

Том малын зүй бус хорогдол (мян.тол)

	1991- 1995 оны дундаж	1990	1995	1996	1997	1998	1999	2000
Тэмээ	16.6	31.2	7.5	8.4	6.0	6.3	6.9	18.5
Адуу	76.7	70.4	48.1	53.2	45.1	50.7	72.8	393.9
Үхэр	132.9	73.1	84.6	79.8	110.6	111.4	127.0	630.5
Хонь	579.1	369.4	403.2	288.7	278.9	344.2	344.9	1416.9
Ямаа	167.7	129.1	130.5	156.7	177.1	273.0	248.4	1031.4
Бүгд	973.0	673.2	673.9	586.8	617.7	785.7	800.1	3491.2

Зудад хүндээр нэрвэгдсэн Дундговь, Завхан, Төв, Баянхонгор, Увс, Өвөрхангай, Өмнөговь аймагт 2649.2 мянган том мал зүй бусаар хорогдсон нь улсын хэмжээний нийт хорогдлын 75.9 хувийг эзлэж байна. (Хавсралт 26)

Оны эхний малд зүй бус хорогдолын эзлэх хувь

	1991-1995 оны дундаж	1990	1995	1997	1998	1999	2000
Тэмээ	3.7	5.6	2.0	1.7	1.8	1.9	5.2
Адуу	3.4	3.2	2.0	1.6	1.8	2.4	12.5
Үхэр	4.7	2.7	2.8	3.2	3.1	3.4	16.5
Хонь	4.0	2.6	2.9	2.1	2.4	2.3	9.3
Ямаа	2.9	2.6	1.8	1.9	2.7	2.2	9.3
Бүгд	3.8	2.7	2.5	2.1	2.5	2.4	10.4

Том малын зүй бус хорогдолын 9.3 хувь буюу 323.6 мянга нь өвчнөөр, 90.7 хувь буюу 3.2 сая нь зуд, гэнэтийн аюулаар хорогдов.

Том малын зүй бусын хорогдол (мян.тол)

	1996	1997	1998	1999	2000
Мэдээгээр					
7-р сарын					
1-ны	289.0	453.1	615.2	585.9	2892.7
10-р сарын					
1-ны	326.7	493.8	660.1	591.0	3005.7
Мал тооллогоор	586.8	617.7	785.7	800.1	3491.2

1990 оноос хойш малын зүй бус хорогдол хамгийн бага болон их гарсан жил

	Хамгийн бага хорогдол гарсан		Хамгийн их хорогдол гарсан	
	мян.тол	он	мян.тол	он
Бүгд	586.8	1996	3491.2	2000
Тэмээ	6.0	1997	31.2	1990
Адуу	41.6	1994	393.9	2000
Үхэр	73.1	1990	630.5	2000
Хонь	278.9	1997	1416.9	2000
Ямаа	129.1	1990	1031.4	2000

Малын хээл хаялт, сувайралт. 2000 онд оны эхний хээлтэгч малын 19.1 хувь буюу 2699.9 мянга нь хээл хаяж, сувайрсан нь сүүлийн 50 жилд гарч байгаагүй үзүүлэлт юм. Энэ нь өмнөх оныхоос 786.9 мянгаар нэмэгдсэн байна.

Нийт төл өгөөгүй хээлтэгч малын 74.5 хувийг эм хонь, ямаа эзлэж байгаа юм.

Баянхонгор, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгуудад оны эхний хээлтэгч малын 22.0-32.8 хувиас дээрхи шалтгаанаар төл авч чадсангүй.

(Хавсралтын дугаар 28, 29)

Хээл хаяж, сувайрсан эх малын тоо (мян.тол)

	Төл өгөөгүй хээлтэгч мал бүгд				үүнээс сувайрсан		
	1991-1995 дундаж	1999	2000	2000\1999 хувь	1991-1999 дундаж	1999	2000
Ингэ	14.1	9.3	10.4	111.8	11.3	7.7	8.5
Гүү	182.1	220.0	329.1	149.6	138.7	159.2	206.2
Үнээ	263.3	266.2	348.8	131.0	189.0	203.1	250.0
Эм хонь	767.0	647.6	906.0	134.3	538.6	470.9	578.0
Эм ямаа	343.9	742.9	1105.5	148.8	205.8	417.6	451.7
ДҮН	1543.4	1913.0	2699.9	141.1	1083.4	1258.5	1494.4

Нийт хээлтэгчид хээл хаяж, сувайрсан эх малын эзлэх хувь

	Бүгд			үүнээс сувайрсан		
	1991-1995	1999	2000	1991-1995	1999	2000
Ингэ	12.1	9.5	10.3	9.7	7.8	8.4
Гүү	31.3	26.3	35.7	23.8	19.0	22.4
Үнээ	21.8	18.6	24.1	17.4	14.2	17.2
Эм хонь	10.9	10.1	13.2	7.7	7.1	8.4
Эм ямаа	12.7	15.2	22.9	7.6	8.6	9.3
ДҮН	13.4	13.8	19.1	9.3	9.1	10.6

1990 оноос хойш эх малын хээл хаялт, сувайралт хамгийн бага болон их гарсан жил

	Хамгийн бага		Хамгийн их	
	мян.тол	он	мян.тол	он
Бүгд	582.7	1997	2699.9	2000
Ингэ	8.5	1998	16.9	1992
Гүү	152.3	1995	329.1	2000
Үнээ	181.1	1995	348.8	2000
Эм хонь	434.1	1990	906.0	2000
Эм ямаа	172.9	1990	1105.5	2000

Хээлтээгч, хээлтүүлэгчийн тохироо. Үржлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 25-30 хээлтэгч ногдох ёстой байхад одоо улсын дунджаар 71 эм хонь, 70 эм ямаа ногдож, хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо алдагдсан хэвээр байна. Энэ байдал эх малын сувайралт нэмэгдүүлэхэд нөлөөлж, мал өсгөх багагүй нөөц бололцоог алдаж байна. Сүүлийн жилүүдэд бог малын нэг хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тоо 2.0-2.5 дахин нэмэгджээ. (Хавсралт 30)

	дундаж	дундаж						
Бүгд	7559.8	7219.3	7630.4	6567.3	6920.0	7511.4	8743.9	8119.3
Тэмээ	38.9	59.4	47.5	31.6	35.8	30.8	31.9	47.1
Адуу	201.7	203.5	205.3	163.5	304.1	299.8	350.7	477.9
Үхэр	544.3	551.5	525.7	523.9	697.4	755.6	809.4	886.6
Хонь	5311.3	5110.1	5301.3	4627.1	4055.1	4216.7	4397.9	4306.2
Ямаа	1463.6	1294.8	1550.6	1221.2	1827.6	2208.3	3154.0	2401.5

Оны эхний малд эзлэх хувь

	1986- 1990 оны дундаж	1991- 1995 оны дундаж	1990	1995	1997	1998	1999	2000
Бүгд	32.7	28.2	30.9	24.5	23.6	24.0	26.6	24.2
Тэмээ	7.0	13.2	8.5	8.6	10.0	8.7	9.0	13.1
Адуу	9.8	9.0	9.3	6.8	11.0	10.4	11.5	15.1
Үхэр	21.5	19.4	19.5	17.4	20.1	20.9	21.7	23.2
Хонь	39.4	35.4	37.2	33.6	29.9	29.8	29.9	28.3
Ямаа	32.5	22.7	31.3	16.9	20.0	21.5	28.5	21.8

Сүргийн бүтэц. Нийт сүргийн 29.9 хувь нь буюу 9025.9 мянга нь төл, өсвөр насны, 42.8 хувь буюу 13244.3 мянга нь хээлтэгч, 25.3 хувь нь буюу 7640.0 мянган нас гүйцсэн эр мал, 1.1 хувь нь буюу 317.5 хээлтүүлэгч мал байна. Сүрэгт нас гүйцсэн эр мал, хээлтэгч малын эзлэх хувийн жин өсч, төл, өсвөр насны малын хувийн жин буурсан байна. (Хавсралт 13-18)

Сүргийн бүтэц (хувиар)

	Төл, өсвөр насны				Нас гүйцсэн эр			
	1990	1995	1999	2000	1990	1995	1999	2000
ДҮН	38.8	35.2	33.9	29.9	13.0	23.2	22.9	25.3
Тэмээ	32.7	29.2	27.5	25.5	36.1	41.9	42.7	43.8
Адуу	37.6	35.5	32.1	27.7	34.4	34.0	34.8	37.1
Үхэр	49.8	50.9	45.8	43.8	8.5	11.8	14.9	15.6
Хонь	38.4	34.6	34.0	30.8	8.5	21.3	20.3	22.3
Ямаа	35.2	30.2	30.4	25.1	16.2	26.7	25.1	28.5

үргэлжлэл

	Хээлтэгч				Хээлтүүлэгч			
	1990	1995	1999	2000	1990	1995	1999	2000
ДҮН	46.6	40.4	42.2	43.8	1.6	1.2	1.1	1.1
Тэмээ	26.2	27.6	28.5	29.3	0.8	1.3	1.3	1.4
Адуу	24.9	26.7	29.1	30.9	3.1	3.8	3.9	4.2
Үхэр	39.6	35.5	37.9	39.2	2.1	1.8	1.5	1.4
Хонь	51.6	43.4	45.1	46.3	1.5	0.7	0.7	0.6
Ямаа	47.3	42.3	43.8	45.7	1.3	0.8	0.7	0.7

Сүүлийн жилүүдэд сүргийн бүтцэд томоохон өөрчлөлт гарлаа. 1999 онд нас гүйцсэн эр малын тоо 7.7 сая толгойд хүрсэн нь 1990 оныхоос 4.3 сая

толгойгоор өсч байсан бол 2000 онд 1999 оныхоос 38.1 мянган толгойгоор буурсан байна.

Нас гүйцсэн эр малын тоо (мян.тол)

	1990	1997	1998	1999	2000	2000\1999	
						Хувь	зөрүү
Ат	193.8	146.2	145.8	151.7	141.4	93.2	-10.3
Морь	778.2	954.2	986.9	1102.1	988.0	89.6	-114.1
Шар	243.4	558.4	562.5	568.2	483.9	85.2	-84.3
Эр хонь	1286.4	2886.8	2904.8	3081.3	3096.6	100.5	15.3
Эр ямаа	831.8	2645.2	2849.2	2774.8	2930.1	105.6	155.3
ДҮН	3333.6	7190.8	7449.3	7678.1	7640.0	99.5	-38.1

II.2. Цэвэр үүлдрийн болон эрлийз, нутгийн шилдэг омгийн мал.

Цэвэр үүлдрийн болон эрлийз, нутгийн шилдэг омгийн мал. 2000 оны эцэст цэвэр үүлдрийн 731.5 мянга, эрлийз 1109.3 мянга, нутгийн шилдэг омгийн 791.0 мянган мал тоологдов. Цэвэр үүлдрийн мал 1998 оныхоос 4.1 хувь буюу 31.3 мянга, эрлийз мал 1.7 хувь буюу 19.3 мянгаар буурлаа. (Хавсралт 32, 33)

2000 тоологдсон нийт үхрийн 4.4 хувь, хонины 9.7 хувь, ямааны 3.5 хувийг цэвэр эрлийз мал эзлэж байна. Нийт цэвэр, эрлийз малын 94.4 хувь хувийн аж ахуйд, 5.6 хувь нь хөдөө аж ахуйн компани, хоршоо, улсын үйлдвэрийн газар, бусад байгууллагад ногдож байна.

Нутгийн шилдэг омгийн 3.3 мянган тэмээ, 32.9 мянган адуу, 4.4 мянган үхэр, 468.4 мянган хонь 282.0 мянган ямаа тоологдлоо.

Цэвэр үүлдрийн болон эрлийз, нутгийн шилдэг омгийн малын тоо, төрлөөр (мян.тол)

	1990	1995	1998	2000	2000\1999	
					Хувь	зөрүү
1.Цэвэр үүлдрийн бүх мал	506.0	756.1	762.8	731.5	95.9	-31.3
үхэр	80.5	51.4	39.8	29.1	73.1	-10.7
хонь	333.6	626.8	638.8	588.5	92.1	-50.3
ямаа	91.9	77.9	84.2	113.9	135.3	29.7
2. Эрлийз	1345.3	900.3	1128.6	1109.3	98.3	-19.3
үхэр	171.9	112.8	119.2	106.1	89.0	-13.1
хонь	837.4	600.5	795.0	760.1	95.6	-34.9
ямаа	336.0	187.0	214.4	243.1	113.4	28.7
3.Нутгийн шилдэг омгийн	1240.9	616.4	698.0	791.0	113.3	93.0
үхэр	23.4	3.9	5.9	4.4	74.6	-1.5
хонь	1198.0	536.7	467.4	468.4	100.2	1.0
ямаа	14.5	65.2	206.5	282.0	136.6	75.5
тэмээ	5.0	2.9	1.4	3.3	235.7	1.9
адугуу	-	7.7	16.8	32.9	195.8	16.1

Цэвэр үүлдэр, эрлийз малын тоо, аж ахуйн салбараар. (мян.тол)

	Нийт цэвэр эрлийз мал		Үхэр		Хонь		Ямаа	
	1998	2000	1998	2000	1998	2000	1998	2000
Хувийн аж ахуй	1727.4	1737.7	130.4	118.7	1314.4	1271.8	282.6	347.2
Бусад	163.9	103.1	28.5	16.5	119.4	76.8	16.0	9.8
ДҮН	1891.3	1840.8	158.9	135.2	1433.8	1348.6	298.6	357.0
Салбаруудын эзлэх хувийн жин								
Хувийн аж ахуй	91.3	94.4	82.1	87.8	91.7	94.3	94.6	97.3
Бусад	8.7	5.6	17.9	12.2	8.3	5.7	5.4	2.7
Дүн	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

Нийт малд цэвэр үүлдрийн болон эрлийз малын эзлэх хувь

	Үхэр			Хонь			Ямаа		
	1997	1998	2000	1997	1998	2000	1997	1998	2000
Бүгд	4.9	4.3	4.4	9.6	9.8	9.7	3.0	2.7	3.5
Цэвэр	1.4	1.1	0.9	4.3	4.3	4.2	0.9	0.8	1.1
Эрлийз	3.5	3.2	3.4	5.3	5.4	5.5	2.1	1.9	2.4
Үүнээс: Хувийн аж ахуй	4.0	3.5	3.9	9.1	8.9	9.6	3.1	2.6	3.4
Цэвэр	0.8	0.6	0.6	3.8	3.8	4.3	0.9	0.7	1.0
Эрлийз	3.2	2.9	3.3	5.3	5.2	5.4	2.2	1.9	2.4

2000 онд цэвэр үүлдрийн хээлтэгч 425.2 мянга, эрлийз үүлдрийн 659.7 мянган хээлтэгч мал тоологдов. Цэвэр үүлдрийн хээлтэгч малын 3.9 хувь нь үнээ, 84.5 хувь нь хонь, 11.6 хувь нь ямаа байна. Эрлийз үүлдрийн хээлтэгч малын 8.8 хувь нь үнээ, 66.4 хувь нь хонь, 24.7 хувь нь ямаа байна. Нийт цэвэр үүлдрийн малын 58.1 хувь, эрлийз үүлдрийн малын 59.5 хувийг тус тус хээлтэгч мал эзлэж байна.

Цэвэр үүлдрийн болон эрлийз хээлтэгч малын тоо (мян.тол)

					1998\1997
--	--	--	--	--	-----------

	1990	1995	1998	2000	Хувь	Зөрүү
1.Цэвэр үүлдрийн хээлтэгч	267.3	375.4	395.4	425.2	107.5	29.8
Үнээ	38.8	22.3	20.2	16.5	81.7	-3.7
Эм хонь	180.7	312.9	332.1	359.5	108.3	27.4
Эм ямаа	47.8	40.2	43.1	49.2	114.2	6.1
2.Эрлийз үүлдрийн	691.3	425.9	595.8	659.7	110.7	63.9
Үнээ	73.7	47.7	63.1	58.2	92.2	-4.9
Эм хонь	446.5	288.2	409.2	438.3	107.1	29.1
Эм ямаа	171.1	90.0	123.5	163.2	132.1	39.7

Цэвэр үүлдрийн болон эрлийз малын хээлтэгчийн эзлэх хувь

	Үнээ			Эм хонь			Эм ямаа		
	1995	1998	2000	1995	1998	2000	1995	1998	2000
Бүгд	42.6	47.0	55.3	49.0	55.6	43.3	49.1	71.1	59.5
Цэвэр	43.4	41.5	56.7	49.9	56.3	61.1	51.7	58.4	43.2
Эрлийз	42.3	48.8	54.9	48.0	55.1	95.3	48.1	76.1	67.1
Үүнээс: Хувийн аж ахуй	41.1	51.8	56.9	47.4	56.6	58.5	48.1	73.1	59.5
Цэвэр	37.9	55.3	66.5	47.3	62.4	61.0	48.8	62.5	43.2
Эрлийз	41.9	51.1	61.0	47.4	52.4	56.5	47.8	76.8	66.6

III. Малын хашаа, уст цэг

III. Малын хашаа, худаг. 2000 онд улсын хэмжээгээр 36.8 сая толгой малын багтаамжтай, 113.5 мянган хашаа тоологдсон нь 1996 оныхоос хашаа 12.1 мянгаар, багтаамж нь 9.2 сая толгойгоор тус тус нэмэгдсэн байна.(Хавсралт 34-36)

Нийт хашааны 21.1 хувийн бодын хашаа эзлэж байна.Хашааны бүрэлдэхүүнийг авч үзвэл нийт хашааны 10.0 хувь нь дулаан байр, 62.7 хувь нь саравчтай хашаа, 27.2 хувь нь саравчгүй хашаа байна. Дархан-Уул, Завхан, Сүхбаатар, Өмнөговь, Хөвсгөл аймгуудын малын хашааны багтаамж 1996 оныхоос 4.6-202.2 мянган малынхаар буурч байна.

Малын хашааны тоо, багтаамж, хувиар

	1990	1995	19996	2000	2000\1996 хувь
Хашаа бүгд \ мян.ш\	66.2	93.2	101.4	113.5	112.0
Багтаамж \ сая.тол\	30.6	26.9	27.6	36.8	133.3
Үүнээс :					
Дулаан байр	11.1	10.3	10.9	11.4	104.6
Багтаамж	5.0	2.5	2.3	1.8	78.3
Саравчтай	51.2	64.2	69.2	71.2	102.9
Багтаамж	23.6	17.4	17.4	19.5	112.1

Саравчгүй	3.9	18.7	21.3	30.9	145.1
Багтаамж	2.0	7.0	7.8	15.4	197.4
Бодын хашаа \мян\	14.5	18.6	22.0	23.9	108.6
Багтаамж \ сая.тол \	2.7	1.9	2.2	2.8	127.3
Хашаажилтын хувь					
Бог	138.1	111.2	111.8	140.9	126.0
Бод	81.1	60.2	57.5	89.1	155.0

Уст цэг. 2000 оны эцэст улсын хэмжээгээр нийт 30.9 мянган худаг тоологдсоны дотор инженерийн хийцтэй худаг 26.5, энгийн уурхайн худаг 73.5 хувийг эзлэж байна. Нийт худгийн тоо 1996 оныхоос 3.5 мянгаар буурсан байна. Үүний дотор инженерийн хийцтэй худаг сүүлийн жилүүдэд эвдэрч, тоногдон 1990 оноос 16.4 мянга, 1996 оноос 4.8 мянгаар багассан байна. Нийт худгийн 70.2 хувь буюу 21.7 мянга нь бэлчээрт байршиж байна. Ашиглалтгүй худаг 5.8 мянга байгаа бөгөөд 1996 оныхоос 0.5 мянгаар буурчээ. 2000 онд 14.9 мянган метр куб бүхий багтаамжтай 958 мал услах сан тоологдоод байна. (Хавсралт 37, 38)

Уст цэгийн тоо (мян.ш)

	1990	1995	1996	2000	2000\1996 хувь
Худаг бүгд	41.6	34.6	34.4	30.9	89.8
Үүнээс :					
Инженерийн	24.6	14.6	13.0	8.2	63.1
Энгийн	17.0	20.0	21.4	22.7	106.1
Бэлчээрт байршдаг	38.4	26.3	27.6	21.7	78.6
Ашиглагддаггүй	1.1	6.2	6.3	5.8	92.1
Усан сан	4.1	1.9	1.7	1.0	58.8
Багтаамж (мян.куб.м)	39.4	27.7	20.1	14.9	74.1

III.2. Малын бэлчээр , тэжээлийн хүрэлцээ, хангамж

Бэлчээрийн хүрэлцээ. Газар зохион байгуулах албаны 2000 оны тайлангаар манай улсын бэлчээр, хадлангийн талбайг 129.4 сая га байгаа нь 1989 оныхоос 4.2 хувь буюу 5.2 сая гагаар нэмэгджээ. Энэ хугацаанд малын тоо хонин толгойд шилжүүлснээр 61.9 сая болж 11.9 хувь буюу 6.6 сая толгойгоор өссөн байна.

Малын тоо толгой өссөнтэй холбогдон 100 га бэлчээр, хадлангийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо 1989 онд 43 байсан бол 2000 онд 48 болж нэмэгдэв.

Одоо 100 га бэлчээр, хадлангийн талбайд Орхон аймагт 840 толгой, Дархан-Уул аймагт 219, Улаанбаатарт 201 толгой, Булган, Архангай, Хөвсгөл аймагт 103-140 толгой (хонин толгойд шилжүүлснээр) мал ногдож байгаа нь

аймгууд дотроос бэлчээрийн ачааллын хувьд хамгийн өндөр үзүүлэлт болж байна.

1989 оныхоос ихэнх аймгийн 100 га бэлчээрийн талбайд ногдох мал нэмэгдсэний дотор бэлчээрийн хүрэлцээ Орхонд 3.8 дахин, Дархан-Уулд 2.0 дахин, Архангай, Булган аймагт 1.6 дахин багасчээ.

Бэлчээрийн хүрэлцээ, аймаг, нийслэлээр

	Хадлан, бэлчээрийн талбай (мян.га)			100 га хадлан, бэлчээрийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо			2000\1989 хувь
	1989	1993	2000	1989	1993	2000	
АР	4536.3	4541.7	4255.0	85	89	140	164.4
БӨ	4178.6	4178.7	4411.9	56	43	49	88.2
БХ	9067.0	9067.0	11027.1	31	33	37	118.4
БУ	3173.1	3178.3	2708.5	79	85	127	161.3
ГО	8924.2	9491.4	12152.6	30	28	24	79.9
ДО	10592.4	10132.7	10260.6	20	17	22	111.3
ДД	9967.3	9966.9	11952.7	21	19	21	99.4
ДУ	7392.3	7377.9	7364.6	39	38	30	77.2
ЗА	6854.5	6855.7	6751.7	56	56	53	93.9
ӨВ	5982.9	5982.8	5913.3	68	72	69	101.7
ӨМ	14597.8	14597.7	12227.8	14	12	20	145.3
СҮ	6873.3	6876.6	8155.8	35	39	45	129.8
СЭ	1959.7	1946.0	1566.3	57	57	93	162.5
ТӨ	6040.7	5828.4	5204.0	62	65	86	137.9
УВ	5684.4	5684.2	5690.1	59	54	46	78.3
ХО	5995.5	5995.1	6576.2	50	52	48	95.2
ХӨ	5629.1	5355.3	5706.3	76	81	103	135.9
ХЭ	6405.8	6290.5	6407.5	50	45	58	115.7
ДА	190.2	190.2	200.6	110	165	219	199.4
УБ	58.2	58.2	289.3	691	1155	201	29.1
ОР	53.6	53.5	33.1	222	478	840	378.5
ГС	-	459.7	538.6	-	41	44	
ДҮН	124156.9	124108.5	129393.4	43	43	48	112.7

Малын тэжээлийн үйлдвэрлэлт, хангамж. 2000 онд улсын хэмжээгээр 357.4 мянган тонн тэжээлийн нэгжтэй тэнцэх хэмжээний тэжээл үйлдвэрлэсэн нь 1999 оныхоос 2.8 хувь буюу 10.3 мянган тонноор буурчээ.

Тэжээл үйлдвэрлэлийн хэмжээ (тэжээлийн нэгжид шилжүүлсэнээр) 13 аймагт буурсны дотор Төв, Улаанбаатар, Өвөрхангай аймгуудад 22.6-36.2 хувиар багасчээ.

2000 онд улсын хэмжээгээр 689.4 мянган тонн байгалийн хадлан бэлтгэсэн нь өнгөрсөн оныхоос 25.8 мянган тонн буюу 3.6 хувь буурчээ. Өвөрхангай, Төв

Хэнтий аймагт бэлтгэсэн өвсний хэмжээ өмнөх оныхоос 13.0-35.3 хувиар буурсан байна. (Хавсралт 30 – 33)

Тэжээлийн хэмжээг нэр төрлөөр үзүүлбэл : (мян.т)

	1986\1990 дундаж	1991\1995 дундаж	1997	1998	1999	2000	2000\1999 хувь
Байгалийн хадлан	1154.2	733.7	667.7	667.0	715.2	689.4	96.4
Сүрэл	114.1	47.2	16.1	15.9	14.3	21.8	152.9
Ногоон тэжээл	255.6	23.9	3.2	2.2	1.5	3.8	253.3
Гар тэжээл (тэж.нэгж)	21.7	9.6	11.3	20.3	13.0	11.9	91.5
Бэлтгэсэн дарш	277.7	66.2	10.3	7.9	2.9	1.3	44.8
Эрдэс тэжээл	61.9	18.1	19.4	26.2	24.1	25.5	105.8
Үйлдвэрлэсэн тэжээл бүгд(тэж.нэгж)	999.4	437.9	340.2	330.3	367.7	357.4	97.2

Сүүлийн жилд нийт тэжээлд хүчит, шүүст болон бүдүүн тэжээлийн эзлэх хувийн жин буурсан байна.

Үйлдвэрлэсэн тэжээлийн бүтэц, тэжээлийн хангамж

	1995	1996	1997	1998	1999	2000
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
хүчит	7.4	3.3	4.2	1.6	0.9	0.9
шүүст	1.8	1.4	2.1	0.6	0.3	0.1
бүдүүн	87.4	92.5	90.0	91.7	88.7	88.5
Бусад	3.4	2.8	3.7	6.1	10.1	10.5
Хонин толгойд шилжүүлсэн нэг малд ногдох тэжээл (тэж.нэгж,кг)	7.1	5.5	4.9	4.7	5.1	5.8

2000 оны байдлаар хонин толгойд шилжүүлсэн нэг малд ногдох тэжээл 1999 оныхоос 0.7 кг-аар өсч, тэжээлийн нэгжээр 5.8 кг тэжээл ногдож байгаа нь нийт малыг 2.8 хоног тэжээх нөөцтэй гэсэн үг юм.

IV. Тэжээвэр амьтад.

2000 оны эцэст 14.7 мянган гахай, 89.1 мянган шувуу, 680 цаа буга, 890 илжиг, 1530 бүл зөгий тоологдов. Урьд оныхоос гахайн тоо 7.2 мянгаар буурч, шувууны тоо 11.0 мянгаар өссөн байна.

Тэжээвэр амьтад, тэдгээрийг өсгөж, үржүүлдэг өрхийн тоо

	1990	1995	1997	1998	1999	2000	2000\1999
Гахай (мян.тол)	134.7	23.5	20.8	19.9	21.9	14.7	67.2
Шувуу (мян.тол)	326.2	99.3	65.1	66.6	78.1	89.1	114.1
Цаа буга	3231	900	619	643	662	680	102.7
Илжиг	1018	913	953	1510	1491	890	59.7
Зөгий бүл	4768	1165	977	1057	1154	1530	132.6
Туулай	7179	118	105	193	189	48	25.4
Үнэг	1251	568	50	28	45	25	55.6
Гахайтай өрхийн тоо (мян)	12104	4156	2870	2945	3441	2568	74.6
Шувуутай өрхийн тоо (мян)	1336	2218	2063	3402	1957	1628	83.2

Нийт гахайн тоо урьд оныхоос 5 аймаг, хотод, шувууны тоо 13 аймаг, хотод өссөн байна. (Хавсралт 39 – 41)

2000 онд аминдаа гахайтай өрх 2.7 мянга, шувуутай өрх 1.6 мянга болсон нь 1999 оныхоос гахайтай өрх 873-аар, шувуутай өрх 329-аар буурсан байна.

Одоо нийт гахайны 87.8 хувь, шувууны 24.5 хувь нь хувийн аж ахуйд байна.

Гахай, шувууны тоо, өмчийн төрлөөр (мян.тол)

	Гахай				Үндсэн мэгж		
	1999	2000	2000\1999 хувь	Хувийн жин	1999	2000	2000\1999 хувь
Дүн	21.9	14.7	67.1	100.0	6.6	4.6	69.7
Үүнээс: хувийн	18.8	12.9	68.6	87.8	5.5	4.3	78.2

үргэлжлэл

	Шувуу				Өндөглөгч		
	1999	2000	2000\1999	Хувийн жин	1999	2000	2000\1999
Дүн	78.1	89.1	114.1	100.0	69.7	75.2	107.9
Үүнээс: хувийн	16.6	21.8	131.3	24.5	11.2	16.5	147.3

ДҮГНЭЛТ, САНАЛ

2000 оны мал тооллого нь 5 төрлийн малаас гадна хөдөө аж ахуйн тэжээвэр амьтад, хашаа, худаг, уст цэг, тэжээл, ХАА-н үйлдвэрлэлд ажиллаж байгаа боловсон хүчин, ашиглагдаж байгаа машин, техник зэргийг хамруулан тоолсноороо онцлогтой юм.

2000 онд нийт 191.5 мянган малчин өрх мал аж ахуйн үйлдвэрлэлд ажиллаж байна. Малчин өрхийн 10.6 хувь нь цахилгаан гэрэлтэй, 12.8 хувь нь телевизортой, 8.7 хувь нь автомашинтай, 16.6 хувь нь мотоцикльтэй, 1.5 хувь нь трактортой байна. 1999 оныхтой харьцуулахад цахилгаан гэрэлтэй өрхийн тоо 0.3 мянга, телевизортой өрхийн тоо 2.6 мянгаар буурч, автомашинтай өрхийн тоо 4.8 мянга, мотоцикльтой өрхийн тоо 2.6 мянгаар өсчээ.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд малын эмч 2.0 мянга, мал зүйч 1.1 мянга, агрономич 0.5 мянга, 4.3 механикжуулагч ажиллаж байна. Мөн хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд 4.7 мянган трактор, 1.1 мянган үр тарианы комбайн, 1.1 мянган анжис, 2.0 мянган тариа үрлэгч зэрэг машин техник ашиглагдаж байна.

Улсын хэмжээгээр 36.8 сая толгой малын багтаамж бүхий 113.5 мянган хашаа тоологдсон нь 1996 оныхтой харьцуулбал хашаа 12.1 мянга, багтаамж 9.2 сая толгойгоор нэмэгджээ. 2000 онд нийт 30.9 мянган худаг тоологдсоны 8.2 мянга нь инженерийн хийцтэй, 22.7 мянга нь энгийн худаг байна. Худгийн тоо 1996 оныхоос 3.5 мянгаар буурчээ. Үүний дотор инженерийн хийцтэй худаг 1990 оныхоос 16.4 мянга, 1996 оныхоос 4.8 мянгаар багассан байна.

2000 онд мал сүргийн тоо 30.2 саяд хүрч өмнөх оныхоос 3341.4 мянган толгойгоор таван төрөл дээрээ буурлаа. Малын тоо буурахад нөлөөлсөн гол зүйл нь өнгөрсөн өвөл, хаврын цас зудын хүндрэл боловч сүүлийн жилүүдэд таван төрлийн малын харьцаанд болон дотоод бүтцэд томоохон өөрчлөлт гарсан, мал эмнэлэг хувьчлагдсанаар мал сүргийн удмын сан хамгаалах, сүргийн бүтцийн зохистой харьцаа алдагдаж бэлчээрийн нөөц хүрэхгүй болсон зэрэг юм.

Иймд бэлчээрийн даацдаа тохирсон, ашиг шим өндөртэй малыг өсгөн үржүүлэхийн тулд малын үүлдэр, угсаа, удмын санг сайжруулахад зохих байгууллагууд анхаарал тавьж ажиллах шаардлагатай байна.

Нөгөө талаас малчид өөрсдөө өвөлжилтийн бэлтгэлийг эртнээс чанартай хийх, өвс, тэжээлээ бэлтгэх, нөөцлөх, мөн малаа даатгуулахын ач холбогдлыг сайтар ойлгох нь нэн чухал юм.

Энэ талаархи ухуулга, суртчилагааг холбогдох байгууллага үүний дотор малчидтай өөр холбоотой байдаг сум, баг, хорооны засаг дарга нар сайтар хийх нь зүйтэй байна.

Манай улс сүүлийн жилүүдэд малын гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулалт хийлгүйгээр хилээр гаргаж байгаа бөгөөд 2000 онд хонины арьс 2507.5, ямааны арьс 84.6, үхрийн шир 1053.1, адууны шир 210.3 мянган ширхэг, хонины самнаагүй ноос 4902.5 тэмээний ноос 792.9, бохир ноолуур 715.8 тонн, мах 12.9 мянган тонныг тус тус экспортод гаргасан байна.

Малын гаралтай бүтээгдэхүүнийг дотооддоо боловсруулалт хийн гадаадад экспортлох боломжийг нэмэгдүүлэх арга замыг хайх, үүний тулд үндсэндээ зогсолтын байдалд байгаа үндэсний үйлдвэрлэлээ сэргээх, дэмжих хэрэгтэй байгаа юм.

2000 онд гахай, илжиг, туулай, үнэг зэрэг тэжээвэр амьтадын тоо буурч, шувуу, зөгий, цаа буга өсчээ.

Гахайны тоо өмнөх оныхоос 7.2 мянгаар буурсан бөгөөд ялангуяа өсгөн үржүүлэх боломжтой Сэлэнгэ, Төв, Хөвсгөл, Өвөрхангай аймгуудад хорогдсон нь тэжээл ховордсон, үнэ өссөн зэргээс шалтгаалж байгаа юм.

Тооллогын үеэр гарсан саналууд

Ховд, Дорнод, Өмнөговь, Сүхбаатар, Улаанбаатар, Булган, Завхан, Увс, Өвөрхангай аймгуудаас 2000 оны мал тооллоготой холбоотой дараахи саналуудыг тавилаа.

Тооллого явуулах хугацааны талаар:

Мал тооллогыг намрын урин дулан цагт \ 9-10 \ сард явуулах. Энэ үед зардал мөнгө бага гарч, бүх мал тооллогонд бүрэн хамрагдах ач холбогдолтой.

Отор нүүдэл ихтэй өвлийн улиралд тооллого явуулахад 7 хоногын хугацаа хүрэлцэхгүй байгааг харгалзан 10-15 хоног болгох.

Хөдөө, орон нутагт хашаа, худаг маш их эвдэрч тоногдож байгаатай уялдан хашаа, худгийн тооллогыг жил бүр хийж байх шаардлагатай.

Зарцуулах хөрөнгөний талаар :

Мал тооллогыг явуулахад хөрөнгө мөнгөний хомсдол нь тооллогын ажлыг зохион байгуулахад ихээхэн хүндрэл учруулж байгаа тул Санхүү, эдийн засгийн яам мал тооллого явуулах зардлыг орон нутгын төсөвт тусгайлан тусгаж өгөх талаар анхаарах зэрэг саналууд болно.

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН

ГАЗРЫН ДАРГА.....Ч.ДАВААСҮРЭН